



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/91

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.20 дахь заалт, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар дүйлийн 8.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 4.1.1, 4.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төсөвт байгууллагуудад дотоод хяналт хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: О.Отгонтуяа (Төсвийн ерөнхий нягтлан бодогч)
Гишүүд: Г.Доржханд (Хууль, эрх зүйн мэргэжилтэн)
Э.Дашдулам (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)
Г.Сугар (иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дотоод хяналт шалгалт олон нийттэй харилцах мэргэжилтэн)
Б.Сангицэрэн (1 дүгээр Цэцэрлэгийн нягтлан бодогч)
Ж.Чимэдбалжир (1 дүгээр Цэцэрлэгийн нярав)
Д.Нямдорж (Ерөнхий боловсролын сургуулийн нярав)

2. Төсөвт байгууллагуудад дотоод хяналт шалгалт хийх төлөвлөгөө гарган батлуулж, тогтоосон хугацаанд дотоод хяналтыг хариуцлагатай, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн дарга (О.Отгонтуяа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  С.АМГАЛАН

